

МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСАГ, ЗҮҮН ХОЙТ АЗИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Д.Баажийхүү*

Японы талын санаачлагаар Зүүн хойд Азийн хамтын ажиллагааг тусд нь судалж хэлэлцдэг болсноос хойш арав гаруй жил өнгөрчээ. Монгол Улс эдийн засгийн сектортоо энэ хугацааг юутай үдэв, цаашид яавал зүйтэй бол гэсэн санааг энд толилуулж байна.

Монголын гадаад орчин

Юуны өмнө дэлхий дэх нийгмийн байгууллын хоёр системийн улс төр, цэрэг, үзэл суртал, эдийн засаг зэргийн конфронтац намжсан явдал улс төрийн ардчилал улс орнуудыг улам бүр хамран, тэдгээрийн өөрсдийнх нь төдийгүй өөр хоорондын үйл ажиллагаа либералчлагдан, зүйл бүрээр өргөжсөн, зах зээлийн хэвийн өрсөлдөөн давамгайлсан нэгэн үеийн чухал нөхцөл болсон төлөвтэй. Нийгмийн эрс тэс өөр гэгддэг хоёр байгууллын зарим конвергенц жишээлбэл капиталист оронд нийгмийн баримжаат төрийн бодлогыг хүчтэй болгох, социалист оронд зах зээлийн механизмыг төвлөрлийг сааруулахтай хослох, аль аль нь нээлттэй болох зэрэг хандлага илүүтэй болсон нь одоо л ажиглагдсан биш байх аа. Улс төрчдөөс дэгдээдэг конфронтац, туйлшралын битүү мананд хоёр системийн сэргөлдөөн гол бус диалектик бодит холбоо, ижил төстэй үйл явц байгаагийн нотолгоо энэ байж болох. Нөгөөтэйгүүр системийн сэргөлдөөн намжихаар дэлхийн улс төрийн бодлогын, зах зээлийн, технологийн өрсөлдөөн, глобалчлал улс орон, үндэстнүүдийн хооронд, тэдгээрийг хамран улам тэлж байна. Системийн сэргөлдөөн намжихаар улс

* Судлаач, доктор (Ph.D)

орнууд дэлхийн тавцан дээр бүлэглэж хамтрахыг эрмэлзэхийн сацуу их, бага гүрэн, улс задрах хандлага ажиглагдлаа.

Өнөөгийн глобалчлал нь өрсөлдөөнөөр эрч хүчээ авч, суурь чадавхи сайтай, түрүүлэн хөгжин дэвшиж буй улс, үндэстний ололт, амжилтыг дэлхий даяараа хуваалцах олон талын ач тустай, дэлхийн хөгжлийг урагшуулж буй үйл явц гэж үзүүштэй. Нөгөөтэйгүүр, ямар ч шалтгаантай байлаа энэ глобалчлалд конфронтацийг гегемончлолоор, үзэл суртлыг ёс суртахууны түрэмгийлэл, терроризмаар эзэмдэх илрэл байна. Хүчтэй, хөгжингүй гүрнүүдийн санхүүгийн болон технологийн түрэмгийлэл, дэлхийн үндсэн түүхий эд төдийгүй ерөөсөө түүхий эдийн зах зээлийг хяналтдаа байлгах хараат бодлого эдийн засгийн глобалчлалын цөм байсаар хэвээр. Үүнээс улбаатай улс төр, цэрэг, ёс суртахууны томоохон хямрал олон улсын талбарт үүсч, энэ нь эргээд дэлхийн эдийн засагт сөргөөр нөлөөлөх төлөвтэй. Зах зээлийн өрсөлдөөн дэлхийн эдийн засгийг бүхэлд нь хамрах болсон эдүгээ үед эл өрсөлдөөнийг тэтгэх гол хүч болсон “амиа хичээх үзэл” зөвхөн хувь хүн эсхүл компанид үйлчилдэг бус улс, гүрний түвшинд үндэсний ашиг сонирхол гэдэг номлолын дор хүчтэй ноёрхож байгаа нь улс хоорондын, бүс нутгийн, дэлхий даяарх бодит хамтын ажиллагааны альтернативын үндэс болж байна.

Дэлхий дахинаа улс төрийн уур амьсгал зарим талаар зөөлөрсөн ч эдийн засгийнх нь өсөлт 1980-1990 онд 3.3% байсан бол 1990-2000 онд 2.7%¹ болов. Энэ бууралт ялангуяа нэн бага орлоготой улсуудад илүү хүчтэй буюу 4.5%-иас 3.2%-д хүрэв. Дээрх харьцуулсан хугацаанд нийт 163 улсын 65-ынх нь эдийн засагт өсөлт өмнөх арван жилээсээ багассан эсхүл уналт бий болжээ. 1980-1990 онд эдийн засгийн уналт гарсан улс 10 байсан бол 1990-2000 онд 23 болов.

Хөгжингүй орнуудаас үзүүлдэг хөгжлийн албан ёсны дэмжлэг сүүлийн жилүүдэд, тухайлбал 1995 онд 59 тэрбум америк доллараас 2000 онд 54 тэрбум хүртэл багассан ч нэн бага, дунд орлоготой улсуудын гадаад өр 1990 онд 1458 тэрбум америк доллар байснаа 2000 онд 2491 тэрбумд хүрч, өрийн үйлчилгээ 200 тэрбумаас аль хэдийн давсан. Эдийн засгийн дорвитой өсөлт гараагүй эсхүл уналтад орсон бүлэг улсуудын өр үлэмж өссөн явдал олон улс, үндэстэн өрийн дарамтад улам гүн шигдэж, улмаар дэлхийн хөгжлийг сааруулсан гэж үзэх үндэстэй юм.

¹ World Development Indicators 2002. The World Bank. CD. Цаашид дэлхийн хөгжлийн тоо баримтыг үүнээс авав.

Дэлхийн хэмжээгээр барааны экспорт сүүлийн 10 жилд 85% өсөхөд импорт нь 87% болж, хөгжингүй улсуудын барааны худалдаа алдагдалтай, хөгжиж буй улсуудынх ашигтай байв. Энэ нь хөгжингүй улсуудын үндэстэн дамнасан корпорацууд бусад орнуудад тархан байрших нь илүү болж, хөгжиж буй орнууд анхдагч болон хоёрдогч түүхий эдээ их хэмжээгээр хямд үнээр гадагш зөөж байгаатай холбоотой. Хөдөө аж ахуйн түүхий эд, хүнсний зүйл, металл, эрдсийн дэлхийн зах зээлийн үнэ 2001 онд 1990 оноос 11-25% буурсан байхад эрчмийн түүхий эдийн үнэ 10-65% нэмэгдэв. Улс хоорондын барааны худалдааны сацуу үйлчилгээний дэлхийн экспорт дээрх хугацаанд 91%, импорт нь 81% өсч ялангуяа өндөр хөгжилтэй улсуудын экспортын үйлчилгээ нэн давамгайллаа.

Дэлхийн улс орнууд өөр хоорондоо 1990 онд 200 тэрбум америк долларын шууд хөрөнгө оруулалт хийж байсан бол 2000 онд 1168 тэрбумд хүрсний 86% нь өндөр орлоготой орнуудад ногдож байна.

Ийм мэтийн эдийн засгийн төдийгүй төрөл бүрийн бусад чиглэлийн эерэг, сөрөг үзэгдэл, үйл явц, урсгал байсан нь ойлгомжтой бөгөөд товчлон хэлэхэд энэ бүхний эцсийн дүнд дэлхийн хүн амын амьдрал өнгөрсөн арван жилд өмнөх арван жилээсээ илүү дээрдсэнгүйг дэлхийн статистикийн үзүүлэлтүүд харуулна.

Зүүн хойд Азийн 6 улсад дэлхийн хүн амын 26.5%, нутаг дэвсгэрийн 21.5%, үйлдвэрлэсэн үндэсний орлогын 20% байршиж байгаа бөгөөд нэг хүнд ногдох үндэсний орлогоор дэлхийн дунджаас даруй 25%, өндөр орлоготой Япон, Өмнөд Солонгосыг эс тооцвол бүр 5.7 дахин доогуур байна. Энэ бүс нутагт улс төр, үзэл суртлын уур амьсгал нэлээд тогтуун байсан нь ялангуяа 1999, 2000 оноос эдийн засгийн өсөлт эдгээр улсад бараг бүгдэд нь бий болоход дөхөм болсон болов уу, дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) Хятадад 7-7.9%, Өмнөд Солонгост 8.8-10.9%, Японд 0.8-2.4%, Орост 5.4-8.3%, Монголд 1.1-3.2% өсөв. Бүс нутагт хоёр талын төдийгүй олон талт хамтын ажиллагааг өрнүүлэх эрмэлзэл байгаа ч хөгжил орон бүрт жигдэрч чадсангүй, ялгаа нь улам ихэсч байна. Нэг хүнд ногдох ДНБ 1990-2000 онд жилд дунджаар Хятадад 9.2%, Өмнөд Солонгост 4.7%, Японд 1.1% өссөн байхад Орост 4.6%, Монголд 0.3%-иар буурав. Монгол, ОХУ-д эдийн засаг нь сэргээгүй байна (хүснэгт 1).

Хүснэгт 1

Улс	2000 он/1990 он, %	
	ДНБ	Экспорт
Монгол	99.7	70.5
ОХУ	43.4	66.2
Өмнөд Солонгос	181	265
БНХАУ	305	402
Япон	159	167

Монгол Улс 1990 оны үйлдвэрлэлийн түвшинд хүрээгүй, экспортын дөнгөж 70.5%-тай байхад ОХУ-д байдал бүр ч дор байна. Зүүн Өмнөд Азийн санхүү-эдийн засгийн 1997 оны хямрал бас бус хүчин зүйл Өмнөд Солонгос, Японы өсөлтийн хурдцыг сааруулахад нөлөөлсөн. Хятадын эдийн засаг 1970-аад оны сүүлээс хойш дэлхийд гараагүй хурдцаар хөгжсөөр байгааг бид бүгд мэднэ.

Зүүн хойд Азид либералчлал, нээлттэй бодлого, өөрийн агуулга, өнгө аястай, нэлээд хүчтэй газар авч байна. Хамрах хүрээ, агуулга, жингээрээ энэ либералчлал дэлхийн аль ч бүс нутагт байхгүй гэж үзэж болно. ОХУ, Монголд нийгмийн байгууллын статусаа өөрчилсөн, ялангуяа улс төр, үзэл суртал, эдийн засагт эрс шинэчлэл рүү орсон бол БНХАУ-д нийгмийн өөр өөр байгууллын конвергенцийн номлолыг шинэ маягаар, амжилттай хэрэглэж байгаа шинжтэй. Бүс нутгийн хоёр их гүрэнд либералчлал өргөжихийн хэрээр Япон, Өмнөд Солонгосоос тэдгээртэй харилцах тавцан өргөжиж байна. Үнэн хэрэгтээ улс төрчдийн гайгаар гэж хэлж болох хагас зууны өмнө солонгос үндэстнийг хуваасан цөвүүн үе эдүгээ үргэлжилсээр байгаа нь энэ бүсийн хамтын ажиллагааг өргөжүүлж гүнзгийрүүлэхэд нэг тээг болж буй шинжтэй.

Монгол Улс эдийн засгийн хувьд Зүүн хойд Азид тун бага жин эзэлдэг бөгөөд түүний жижиг нь үүгээр харагддаг (хүснэгт 2).

Хүснэгт 2

	Хүн ам, сая	Нутаг дэвсгэр, мян. км ²	Үндэс-ний орлого, тэрбум \$	Экспорт, тэрбум \$	Импорт, тэрбум \$	Гадаадын шууд хөрөнгө оруулалт, сая \$
Зүүн хойд Ази, 2000 он	1606.4	28834	6250	1006.4	881.6	58653
Үүнээс: Монголын эзлэх хувь	0.01	0.14	0.01	0.04	0.06	0.05

Монгол Улс Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн болоод 5 жил гаруй болсон, 2002 оны байдлаар дэлхийн 88² улстай худалдаа хийж, 70-аад улсын 2000 гаруй компани Монголын нутагт үйл ажиллагаа явуулж, сүүлийн жилүүдийнгадаадын хөрөнгө оруулалт 600 сая америк доллараас давсан зэрэг нь эдийн засаг нь нээлттэй болж буйн илрэл, либералчлагдаж буйн шинж төдийгүй Монгол Улстай хамтрах эрмэлзэл өссөнийг харуулна, Монголын гадаад худалдааны геодиверсификац болж байгааг илтгэнэ. Монголын гадаад худалдааны 1999-2002 оны нийт эргэлтэд БНХАУ, ОХУ, Япон, БНСУ, БНАСАУ нийлээд 2/3-оос илүүг эзлэх болсон, гадаадын хөрөнгө оруулалтын зонхилох нь эхний 4 улсын компаниудад ногдож байгаа, Монголд үзүүлж буй хөгжлийн албан ёсны дэмжлэгийн 70% Япон Улсад ногддог зэргээс үзвэл Монголын хувьд Зүүн хойд Азийн бүсийн интеграц бас болж байна, Монголын хөгжилд энэ бүс нутгийн улсууд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж байна, цаашид ч энэ хандлага хэвээр хадгалагдах үндэстэй гэж үзэж болно. Энэ нь бас бүс нутгийн улсуудтайгаа сайн түншийн харилцааны улс төр, эрх зүйн нөхцлийг бүрдүүлсний үр дүн гэж үзэж болно. Монголын нутагт эдгээр улс, гүрнүүдийн ашиг сонирхлын огтлолцоо, өрсөлдөөн болж байна. Энэ ч зайлшгүй биз. Зүүн хойд Ази дахь зах зээлийн өрсөлдөөн, эдийн засгийн интеграци, хамтын ажиллагааны альтернативууд, бас глобалчлалын хандлага Монгол Улсад хэрхэн нөлөөлж байгааг үүгээр хэмжиж болох талтай. 1990-2000 оны байдлаар бүсийн орнуудын гадаад худалдааны тэнцлийг ажиглахад Япон, ОХУ хоёрт бүх жилүүдэд эерэг байхад БНХАУ-д зөвхөн 1993 онд л алдагдал хүлээжээ. Харин Өмнөд Солонгос 1998 он хүртэл дунджаар 8.4%-ийн сөрөг тэнцэлтэй, Хойд Солонгост бүх жилүүдийн алдагдал дунджаар 50% болов. Монголын гадаад худалдааны тэнцэл сүүлийн 13 жилийн 3-д нь эерэг, бусад жилүүдэд дунджаар 24%-ийн сөрөг үлдэгдэлтэй, ялангуяа 1998-2002 онуудад энэ хувь их дээшлэв. 2002 онд Монголоос Зүүн Хойт Азийн улсуудтай хийсэн худалдаа Хятад, Хойд Солонгосоос бусадтай нь алдагдалтай болов (хүснэгт 3).

Дээр дурдсан зарим тоо баримт нь Зүүн хойд Азийн эдийн засгийн хамтын ажиллагааны эцсийн үр нөлөө Монголын хувьд илүү нааштай байлаа гэж дүгнэх үндэс болохгүй байна.

² Монгол Улсын гадаад худалдааны эмхэтгэл. Гаалийн ерөнхий газар. 2003

Хүснэгт 3

Улс	Экспорт, сая ам.доллар	Импорт, сая ам. доллар	Ашиг (+), алдагдал(-), сая ам.доллар
БНАСАУ	0.03	0.02	+0.01
БНСУ	22.26	80.26	-58.0
БНХАУ	208.93	132.81	+76.12
ОХУ	43.05	224.61	-181.56
Япон Улс	6.3	40.55	-34.25
5 улсын дүн	280.57	478.25	-197.68

Үндэсний зах зээл жижиг улс гадаад харилцаа өргөн байвал өндөр хөгжилтэй болдгийг дэлхийн туршлага харуулдаг. Нэг хүнд ногдох экспорт манайтай ойролцоо хүн амтай Шинэ Зеландад 3491, Норвегт 13343, Сингапурт 34469 америк доллар тус тус байхад бид ердөө 150-аас хэтрээгүй байна. Монгол эл үзүүлэлтээр Япон, Өмнөд Солонгосоос 24-25 дахин, ОХУ-аас 4.8 дахин, БНХАУ-аас 25% доогуур байгаа нь Зүүн Хойт Азийн эдийн засагт төдийгүй олон улсын хөдөлмөрийн хуваарьт оролцох Монголын оролцоо хангалтгүйг харуулна. Ийнхүү Монголын эдийн засгийн хөгжлийн үндсэн асуудлыг Зүүн хойд Азийн улсуудын хүрээний хамтын ажиллагаатай илүү холбох үндэслэлтэй учраас үндэсний эдийн засгийнхаа байдлын талаар зарим дүгнэлт, саналыг товч өгүүлье.

Монголын эдийн засаг сүүлийн 10 гаруй жилд хөгжснэ үү?

Олон улсын тавцан дахь эдийн засгийн нөөц, чадавхи, улс төрийн үүрэг, нөлөө, цэргийн хүч, бодит хамтын ажиллагааны агуулга, хүрээ гэх зэргээрээ хавьгүй их, зарим нь асар том Зүүн хойд Азийн гүрнүүдтэй жишихэд жижигхэн Монгол Улс дэлхийн энэ бүс нутагт *эдийн засаг, технологийн хувьд*:

- нөөцөөр хамгийн хомс,
- чадавхиар хамгийн жижигхэн,
- гаднын хамгийн хүчтэй хараат,
- өрсөлдөх чадвараар хамгийн сул,
- бие даах чадвараар хамгийн дорой,
- аюулгүй байдлаар хамгийн эмзэг,
- эрсдэлээр хамгийн өндөр,
- менежментээр хамгийн муу,
- географийн нөхцлөөр хамгийн үр ашиггүй,

- хөгжлийн түвшингээр хамгийн буурай орон байсан, одоо ч хэвээрээ л байна.

Зүүн хойд Азийн улсуудаас дэлхийн далайн хямд тээвэр, хямд загас бас бус баялгийг гараараа хүртдэггүй ганц улс Монгол хэвээрээ л байна. Хөгжлийн урт хугацааны трендээс үзэхэд нэг хүнд ногдох ДНБ 1980-1990 онд жилд дунджаар 3% өсч байсан бол 1990-2001 онд 0.3%-иар буурсан. Ийм хурдцаар өгсөж уруудвал өндөр хөгжилд хүрэхэд хэцүү. Жилийн 3% хурдацтай хөгжсөн ч 150 орчим жилийн дараа л Японы өнөөгийн түвшинд хүрнэ. Гэхдээ хөгжил рүү өөдрөг үзлээр зүтгэмээр байна.

Монголд нийгэм, эдийн засгийн гүн хямрал үргэлжилсээр. Үүнийг монголчуудын оршин тогтноход эх дэлхийгээс заяасан суурь нөхцөл - цаг уурын хамгийн тааламжгүй нөхцөл, байгаль-цаг уурын хатуу ширүүн үзэгдэл улам гүнзгийрүүлээ.

Эдүгээ Монгол улсад “sustainable development” байгаа мэтээр зарим улс төрчид, судлаачид үздэг. Хэрэв “sustainable development” нь экологи, эдийн засаг, нийгэм, улс төр, соёл, ёс суртахуун зэргийн хүчин зүйлс, секторууд харилцан бие биеэ дэмжсэн, шүтэлцээтэй хөгжил гэсэн өнөөгийн суурь ойлголт байгаа бол минийхээр байдал арай өөрөөр харагддаг. “Sustainable development”-ийн эрхэм зорилгыг ард түмний аж байдлыг дээшлүүлэх явдал хэмээн олон улсын хамтын нийгэмлэгийн түвшинд хүлээн зөвшөөрч тодорхойлсноос үүдвэл, тухайлбал нэг хүнд ногдох үндэсний орлого 1990 оны төвшинд хүрээгүй, нэн бага орлоготой улсуудын дунджаас ч доогуур, дэлхийн 201 орон дотор сүүлээсээ 35-д байна. Монголын нийгэмд ядуурал нүүрэлж, ядуу улсад ядуурал газар авч хүн амын тэн хагасаас илүүтэй нь ядуу, ядуурлын ирмэгт байна, амьдралын чанар доройтсон байна. Яагаад? Энэ асуултад эдийн засгийн үндсэн нөөцүүдийн байдалтай холбон зарим хариулт өгөхийг хичээе.

Монгол улс **хүний нөөцөө** хурдан өсгөх зарчим мөрддөг, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамж, соёлын үйлчилгээнд нь төсвийнхөө дийлэнхийг зориулж ирсэн, буурай, өндөр эрсдэлтэй эдийн засаг нь нийгмийн маш их ачаалалтай, нэг ажиллагч өөрөөсөө гадна 3 хүн тэжээдэг, төрийн бодлогод нийгмийн баримжааг хүчтэй баримталж байдаг, энэ нь эдийн засгийнх нь өсөлтийг сааруулдаг улс юм. Хүн амын жилийн дундаж өсөлт 1960-1989 онд 2.7%³ байснаа 1990-2001 онд 1.25% болсон нь хүн амаа 440 гаруй мянгаар өсгөх нөөцөө алдлаа гэсэн хэрэг юм. Хүн ам бага өсөх

³ Монгол Улсын статистикийн эмхэтгэл. 1999, 2000, 2001. Цаашид Монголын хөгжлийн тоо баримтыг үүнээс авав

болсон нь түүний эдийн засгийн нөхцөл муудлаа гэсэн хэрэг. Монгол улс ажиллах хүчний капиталын нөөцөөр тун хомс. Өнөөгийн нөөц 850 орчим мянган хүн, үүний 46% нь малчид бөгөөд малчдын 87.5% нь ашиг шим бага 200-аас доош малтай байгаа нь амиа аргацаасан аж ахуйтайн шинжийг харуулна. Хүн амын цэвэр өсөлт 2 гаруй дахин багасаж, нүүдэлчин өрхийн малчид сүүлийн 10 жилд 2.9 дахин олширсон зэрэг нь эдийн засгийн өндөр үр ашигтай сектор түргэн бий болгох, хурдан хөгжүүлэхэд хүний нөөцийн талаасаа хүчтэй сөрөг нөлөө үзүүлж байна.

Өмнөх нийгмээс хүн амын эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын секторт хуримтлуулсан нааштай туршлагуудын заримыг өнгөрсөн жилүүдэд бататгасангүй, уналт бий боллоо. Хүн амын боловсролын түвшин нэн доошиллоо. Сургууль завсардалт нэмэгдсэн зэргээс шалтгаалан насанд хүрэгчдийн бичиг үсэг тайлагдалт 1989 оноос хойш буурав. Ерөнхий боловсролын ч, дээд боловсролын ч чанар их буурлаа. Монголын шинжлэх ухаан уналтад ороод сэргэх шинжгүй 10 гаруй жил боллоо. Азидаа нэлээд дээгүүрт орж байсан Монголын эрүүл мэндийн сектор мөн л уналтад ороод сэргэж чадахгүй байна. Эмнэлгийн больницын ор, ажиллагчид аль аль нь 1990 оноос хойш 1/3-ээр цөөрч, эдийн засгийн хувьд зардал багатай, төрийн төсөвт дарамт багатай мэт харагдавч хүн амын эрүүл мэндийн байдлын эцсийн дүн үзүүлэлт сайжирсангүй. Жишээ нь халдварт өвчнөөр өвчлөгсөд 2001 онд 1990 оноос 58%-иар өслөө. Үр хөндөлт их болсноос төрөлт багасч, эмэгтэйчүүдийн эрүүл мэндэд муугаар нөлөөлж буй нь хүн амын нөхөн үйлдвэрлэл дэх согог гэж үзүүштэй. Эрүүл мэндийн сектороос үндэсний макро эдийн засагт үзүүлэх нөлөөний тухай, нярайн төрсөн дундаж жингийн хандлагаар нийгэм дэх ядуурлыг хэмжиж болох тухай Дэлхийн эрүүл мэндийн байгууллага⁴ заасан байх юм. Энэ нөлөө, хэмжүүр ерөнхий хандлагаараа нааштай байсангүй.

Ийнхүү хүний нөөцөд гарсан томоохон сөрөг үзэгдлүүд Монголд үндэсний хөдөлмөрийн бүтээмж уруудаж, Японоос 87 дахин, Өмнөд Солонгосоос 23 дахин, ОХУ-аас 4.4 дахин, БНХАУ-аас 1.8 дахин доогуур болоход хүргэж байгаа нь эл нөөцийн ашиглалт муу байгааг харуулна, хүний хөгжлийн, хүний нөөцийн менежмент, нэн ялангуяа төрөөс нийгмээ зохицуулан удирдах ур чадвар, арга ухаан түргэн сайжирч төлөвшихгүй байгааг харуулна.

Нэг хүнд ногдох газар нутгийн хэмжээгээр Монгол улс нэлээд их, дэлхийн улсууд дотор эхний тавд ордог ч газрын нөөцийн гадаргуугийн баялагаар хомс, цаг

⁴ Macroeconomics and Health: Investing in health for economic development. 2001. WHO web site.

уурын эрс тэс нөхцөлтэй, агаарын туйлын хэм зарим жилд -56° -аас $+45^{\circ}$ хүртэл хэлбэлздэг. Энэ нь хүн амын дундаж наслалт харьцангуй богино, нялхсын эндэгдэл өндөр байх гэх зэргээр хүний нөөцөд эсхүл зузаан ханатай, дулаалга сайтай барилга барьж эдийн засгийн зардлыг өсгөхөд нөлөөлдөг суурь хүчин зүйл юм. Дийлэнх нутаг ургамлын сийрэг нөмрөгтэй эсхүл нөмрөггүй шахам говь, цөлөрхөг бүс, нүцгэн уулс бүхий ай савууд бөгөөд Монгол улсын нийт нутгийн 40 гаруй хувь бороо хуртай цагт ургамлын тачирдуу битүү бүрхүүлтэй байдаг ба бэлчээрийн ургамлын нөхөн ургалт 5, 6, 7 дугаар сард болдог, энэ хугацаанд газрын хөрсний дундаж дулаан хангамж $+15^{\circ}$ -аас $+24^{\circ}$ байдаг⁵. Энэ гурван сард тундас бага багаар боловч унахгүй бол гангийн аюул дараа жилийн 5 дугаар сар хүртэл үргэлжилнэ. Ер нь Монголын нутагт зуны цагт унах хур тундасын дээд хэмжээ 190 орчим мм бөгөөд говь, хээр, Монгол Алтайн бүс нутагт 2 дахин бага юм, давтамж ч хол зайтай. Гадаргуугийн усны нөөц хомсын зэрэгцээ дэлхийн дулаарал зэрэг гол төлөв байгал, цаг уурын үзэгдлээс үүдэн улам багасч байгаа. Монголын газрын нөөц, уур амьсгалын эл онцлогууд түүний хөдөө аж ахуйн хэв шинжийг тодорхойлдог.

Мал сүрэг Монголын эдийн засгийн гол нөөц, суурь аж ахуй байсаар байна. Эл нөөцийг зохих түвшинд уламжлалт аргаар барихад зардал бага орох боловч өндөр эрсдэлтэй, үр өгөөж, ашиг шим бага. Мал аж ахуйг зөвхөн газрын нөөцөд түшиглэн нүүдэллэн бэлчээрлүүлэх замаар эрхэлж байгаагаас байгаль, цаг уурын байнга тохиолддог гамшигаас, бэлчээрийн нөөц их хомсоос эрсдэл өндөр. Бэлчээр хамгаалалтыг бараг хийддэггүй. Том малын зүй бус хорогдол цаг агаар сайн гэгдэх жилүүдэд дунджаар 3-4% байдаг бол 2000-2002 оны ган, зудаар нийт мал сүргийнхээ 29 хувийг хороов. Өнөөгийн Монголын эдийн засгийн суурь салбарт байдал ийм байгаа нь нийт эдийн засгаа түргэн сэргээх, түргэн хөгжүүлэх үндэс болохгүй нь ойлгомжтой. Мал сүргээ зөв байршуулах, өсгөх төрийн зохицуулалтын бодлого төлөвшөөгүйгээс олон аймагт их хэмжээний бэлчээр талхлагдан, хомсдож, зоо-мал эмнэлэг, үржлийн бааз тарж бутран, угаас эрсдэл өндөр нүүдлийн мал сүргийн нөхөн үйлдвэрлэлд хүчтэй сөрөг нөлөө үзүүлэх болов.

Ил хөрсний тариалан эрхлэхэд дулаан хангамжийн хугацаа богино, гангийн давтамж ихээс эрсдэл өндөр, усалгааны арга өргөн хэрэглэх бололцоо бага юм. Хучлага, дулаалгатай, усалгаатай өөрөөр хэлбэл баталгаатай тариалангийн

⁵ БНМАУ-ын улс ардын аж ахуй 60 жилд. Статистикийн эмхэтгэл

⁶ Мөн тэнд

бүтээгдэхүүний үнэ өндөр гардаг, хүн амын орлого бага зэргээс голдуу шалтгаалан энэ чиглэлийг дорвитой хөгжүүлээгүй. Тариалангийн агро-техникийн алсын хараатай, тууштай бизнес бодлого, төлөвлөгөө үндэсний түвшинд ч, аймгийнхад ч одоогоор алга.

Эрчимжсэн хөдөө аж ахуй Монголд хэрэгтэй юу, үгүй юу гэдгийн талаар төвд, орон нутагт дорвитой судалгаа ч алга. Хүн, газар (байгаль) хоёрын хувьд ийм л хоёр өөр “зарчим” мөрдөж ирлээ. Энэ нь “sustainable development”-ийн эх номлолд тохирохгүй нь мэдээж.

Зах зээлд ирээдүй бүхий, эдийн засгаа дорвитойгоор өөд татчих ашигт малтмалын үйлдвэрийн нөөцөөр тун бага. Хүрэн нүүрсний нэлээд нөөцтэй гэж үздэг. Кокс нүүрсний томоохон ордтой ч гадаад зах зээлээ, олборлох санхүүгийн эх үүсвэрээ хараахан олоогүй байгаа. Зэс, алтны цөөн тооны том орд газруудыг ашиглах боломжийг санхүүгийн гадаад, дотоод эх үүсвэр, гадаад зах зээлийн эрэлт хоёр л шийдэх болов уу. Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн 94.1%-д 1:200000 масштабын геологийн зураглал хийсэн хэдий ч 1:50000-ынх дөнгөж 16.2%-тай⁷ байгаа нь ашигт малтмалын үйлдвэрлэлийн нөөц илрүүлэх ажлын цар хангалтгүйг илтгэх ба монголын эдийн засгийг сэргээх суурь нөхцөл гэж үзэж болох геологийн сектор санхүүгийн их хэмжээний хомсдолтой тулгараад байна. Геологи-хайгуулын ажлыг ялангуяа сүүлийн 10 гаруй жилд илт муу хийснээс эдийн засгийг өөд нь татах, экологийн тэнцвэр алдагдуулахгүй байхуйц өндөр үр ашигтай ашигт малтмалын том нөөцүүд үгүйлэгдэж байна. Байгаа бага зэргийн эрдсийн нөөцөө ашиглах, малын түүхий эдийг боловсруулах үндэсний болон олон улсын менежмент их дутаж байна.

Төв Азийн эрс тэс уур амьсгалтай, цөлөрхөг, хуурайшмал бүсэд орших нутагтаа хүн ам, мал сүрэг, тариалан, аж ахуй, суурин газар, байгалийнх нь усны хэрэгцээг зохистойгоор хангах үйл ажиллагааны нухацтай хийсэн, нарийн төлөвлөгөөгүй л байна.

Эд хөрөнгийн болон мөнгөн хөрөнгийн капиталын нөөц маш бага, хомсдол их, шинж чанар, үр өгөөжөөр их доогуур юм. Олон арван жилийн турш Монголын ард түмний хүч, хөлс, гаднын зээл, тусламжаар босгож байгуулсан олон зуун үйлдвэрийн газар, аж ахуйг 1990-ээд оны эхнээс ардчилал, зах зээлд шилжих нэрийн дор тараан бутаргаж, эзэнгүйдүүлэн тоног төхөөрөмжийг нь хаягдал төмрөөр гадаад руу зөөж,

⁷ Монгол Улсын хөрөнгө оруулалтын Чуулгын баримт бичиг. 2002

барилга байшингийн тоосго, бетон эдлэлээр нь хувийн байшин босгон, бидэндээ томоохон томоохон бүхэл бүтэн эдийн засгийн салбаруудыг устгасан гашуун түүх, туйлшрал дээрх хомсдолыг улам ч их болгосон. Дотоодын эх үүсвэрээр санхүүжих хөрөнгө оруулалт дотоодын нийт бүтээгдэхүүнд өнөөдөр дөнгөж 13% байгаа. Гадаад зээл, тусламж нийт хөрөнгө оруулалтын 60 шахам хувийг эзэлж байна. Арилжааны банкны зээлээр хөрөнгө оруулалтын 8%-ийг л санхүүжүүлж байна. Арилжааны банкны зээлийн хүү Лондонгийн биржийн LIBOR-оос 7-14 дахин өндөр байна. Мөнгөн хөрөнгийн капиталын дотоод нөөцийн их хомсдолтой, санхүүгийн хямралын үед чанга байвал зохих төрийн мөнгөний бодлого сул, арилжааны банк, санхүүгийн тогтолцоо тууштай төлөвшөөгүй, үйлдвэрлэл хөгжүүлэх зээлийн тогтолцоогоо бий болгож чадахгүй байгаа, өндөр үр ашигтай, том хөрөнгө оруулалтыг ялангуяа татвараар, мөнгөний чөлөөт үлдэгдлээр дэмжих, гадаадын мөнгөн капиталын урсгалыг үндэсний эдийн засаг руу зүй зохистойгоор оруулах таатай нөхцлийг бүрдүүлэх төрийн бодлого, арга ухаан бүрэн төлөвшөөгүй байгаа зэрэг нь дээрх хомсдолыг улам хурцатгаж байна. Гадаадын хөрөнгө оруулалт бага байгаа нь юуны өмнө гадаадын компаниудын сонирхлыг татахуйц тодорхой төрлийн түүхий эдийн бэлэн нөөц хомстой холбоотой гэж үзвэл зүйтэй болов уу.

Эдийн засгийн гол нөөц үндэсний түвшинд иймэрхүү их хомсдолтой бөгөөд орон нутагт байдал бүр ч дор байгааг орон нутгийн хөгжлийн чадавхиар нь хэмжиж болно (хүснэгт 4). Орон нутаг маань манай эдийн засгийн гол тулгуур юм.

Хүснэгт 4

Аймаг, нийслэлийн нийгэм, эдийн засгийн байр суурь (2001 он)⁸

Аймаг, нийслэл	Хүн ам (мянга) улсынхад элэх хувь	Нутаг дэвс- гэр, мян. км ²	Хүн амын нягт-шал	Ажил-гүйд- лийн түвшин, %	Ядуурлын түвшин, % (бага орлого-той ороод) ⁹	Малын тоо (сая) / улсынхад элэх хувь	Нэг хүнд ног- дох үр жээл, кг	Үйлдвэр- ний аж үйлдвэрт хүнд хувь	Төсвийн орлогоор зарлага
Архангай	98.3/4	55	1.78	4.4	61.9	1.8/7	10	1.9	26.6
Баян-Өлгий	96.9/3.9	46	2.12	13	61.1	1.3/5	...	0.35	22.7
Баянхонгор	85.7/3.5	116	0.74	4.8	54.8	1.6/6.1	...	0.62	33.7
Булган	63.3/2.6	49	1.3	5.5	65.4	1.46/5.6	511	0.3	36.5
Говь-Алтай	64.2/2.6	141	0.45	5.6	49.9	1.7/6.6	9.1	0.25	15.4
Дорноговь	51.5/2.1	110	0.47	2.6	29.3	0.8/3.2		0.4	42.4
Дорнод	74.5/3.1	124	0.6	11.9	60.7	0.8/3	26.8	0.3	34.1
Дундговь	51.3/2.1	75	0.69	3.8	67.1	1.4/5.4		0.2	33.1
Завхан	86.8/3.6	83	1.05	7.3	76.1	1.5/5.7	...	0.3	24.2
Өвөрхангай	114/4.7	63	1.81	4.8	61.1	1.9/7.2	12.1	1.1	34.5
Өмнөговь	47.3/1.9	165	0.29	3.1	45.1	1.2/4.6		0.15	35.2
Сүхбаатар	56/2.3	82	0.68	3.8	55.7	1.4/5.5		0.2	17.7
Сэлэнгэ	102/4.2	41	2.47	3.3	34.8	0.65/2.4	588	3.4	65.7
Төв	96.3/4.1	74	1.3	2.9	39.1	1.67/6.4	184	8.7	43.3
Увс	85.8/3.6	70	1.23	4.3	71.8	1.58/6	28	0.6	25.9
Ховд	88.7/3.6	76	1.17	4.1	58.5	1.5/5.8	16	0.2	24.2
Хөвсгөл	121/5	101	1.2	3.4	50.9	1.8/6.8	87	0.3	26.6
Хэнтий	71.9/3	80	0.9	5.7	54.1	1.36/5.2	41	0.4	28
Дархан-Уул	86/3.5	3	26.2	5.9	47	0.2/0.7	100	3.2	74.1
Улаанбаатар	813/33	5	173	2.7	37.3	0.2/0.8		49.5	87.5
Орхон	76.5/3.2	1	91.1	7.6	57.5	0.2/0.6	20	26.8	95.8
Говьсүмбэр	12.4/0.5	6	2.24	5.3	54.1	0.65/0.2		0.8	68
Дундаж ¹	80.4/3.3	86	0.94	5.5	56.4	1.4/5.4	91	1.09	32.6

¹ Дархан-Уул, Улаанбаатар, Орхон, Говьсүмбэрийг оруулаагүй.

Бүх 21 аймгаас 18 нь бэлчээрийн мал сүрэг, цөөн хүн амаас өөр үйлдвэрлэлийн нөөцгүй, тариалан бараг эрхлэхгүй байна. Аймаг, нийслэлийн түвшинд “sustainable development” гол үзүүлэлтүүдээр ажиглагдсангүй. Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн үндэсний түвшинд 437 мянган төгрөг байхад мал аж ахуйгаас өөр үйлдвэрлэлгүй шахам аймагт тухайлбал Баян-Өлгийд 187⁹ мянга, Говь-Алтайд 402, Дундговьд 192, Өвөрхангайд 337, Өмнөговьд 427, Увсад 174 мянга байх жишээтэй. Зарим аймагт энэ үзүүлэлт нэлээд дээгүүр байгаа нь бүх мал, ялангуяа ноолуурын орлого ихтэй ямаа олонтой холбоотой. Аж үйлдвэр, үйлчилгээ бөөгнөрсөн Улаанбаатар, Орхон, Дархан-Уул зэрэгт бол энэ үзүүлэлт бараг 2-7

⁸ Ядуурлын улсын үзлэгийн нэгдсэн дүн. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам. 2001

⁹ Аймгуудын статистикийн товчооны судалгаанууд. 2000 он.

дахин илүү юм. 18 аймаг төсвийн зарлагынхаа дөнгөж 15-43 хувийг орлогоороо нөхөж байна.

Монгол улсын нийт нутгийн 90% гаруй цөлжилтөд орж болзошгүйг шинжлэх ухааны судалгаа харуулах болов. Энэ бол зөвхөн Монголын асуудал бус Зүүн хойд Азийн, Ази тивийн экологийн тэнцвэртэй холбоотой. Аль ч аймгийн байгалийн нөөцийн болон түүний ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлтийн судалгаа, мониторинг, менежмент маш хангалтгүй юм. Өөрөөр хэлбэл орон нутаг маань эдийн засгийнхаа ганц суурь болсон мал аж ахуй эрхлэх экологийн суурь нөхцлөө муутгасаар байна. Дархан-Уул, Орхон, Говь-Сүмбэр, нийслэлээс бусад мал аж ахуйн аймгууд хоорондоо эдийн засгийн хэлхээ холбоогоор маш сул. Малын түүхий эдийг нийслэл рүү эсхүл хилийн боомтууд руу нийлүүлэх, оронд нь гол төлөв өргөн хэрэглээний бараа өөртөө татах үйлчилгээг аймгууд эрхэлж байна. Ган, зудын нөхцөлд мал оторлох, хадлан бэлтгэх, тариалангийн болон Хангайн бүс нутгаас өвс, тэжээл, гурил нийлүүлэх зэрэг цөөн төрлийн эдийн засгийн үйл ажиллагаанаас өөр аж ахуйн хэлхээ холбоо аймгуудын хооронд байхгүй. Аймаг хоорондын хөдөлмөрийн хуваарь хөгжсөнгүй.

Мал аж ахуйн 18 аймгаас 5 нь 2001 онд 1990 оноос мал сүргээ 23-46% өсгөсөн байхад, 12 аймаг малаа цөөрүүлэв. Гэтэл 2000, 2001 оны ган, зудаар мал аж ахуйн 18 аймгаас нэг нь ч өмнөх оноосоо малаа өсгөсөнгүй. Монгол орны байгалийн бэлчээрийн даац хичнээн малтай, бүтэц нь ямар байхыг тодорхойлогч суурь хүчин зүйл байсаар байгаа. Өмчлөлийн байдал, зохион байгуулалтын хэлбэр, хүний нөөц, хашаа, зоо-мал эмнэлгийн үйлчилгээ гэх зэрэг нь энэ салбарын хувьд суурь хүчин зүйл биш. Мал аж ахуйн бүтээгдэхүүний эрэлт ихэссэн ч мал сүргийн өсөлтийг нь бэлчээр хязгаарлана. Бэлчээрийг сайжруулах, тогтвортой нөөцтэй байлгах, тэжээл бэлтгэх тусгай томоохон арга хэмжээ аваагүй цагт байгалийн эл хууль үйлчилнэ. Манай улсын бэлчээрийн мал сүргийн нөхөн үйлдвэрлэл яаж явах ёстойг нэг талаас бэлчээр, тэжээлийн хангамж, нөгөө талаас бүтээгдэхүүнийх нь зах зээлийн эрэлт энэ хоёр л голлон шийдвэрлэнэ гэсэн хэрэг. Энд юуны өмнө бэлчээрийн мал аж ахуй, экологийн тэнцвэр хоёр сөргөлдөх хүчин зүйлс болоод байгааг харуулна.

Монгол улсын хүн амын дунд цөөн баян, олон ядуусын хоорондох ангал тэлсээр байгаа болон улс төрийн намуудаас нийгмийн амьдралыг төвхнүүлэх талаар урт хугацаатай, алсын хараатай, бодит үндэслэлтэй, ард олны итгэл үнэмшил авчирахуйц хөтөлбөрчилсэн арга хэмжээ авахгүй байгаа зэрэг нь улс оронд улс

төрийн хувьд найдвартай, бат тогтвортой байдал бий боллоо гэх үндэслэлийг төрүүлэхгүй байна. Өөрөөр хэлбэл хөгжлийн улс төрийн дэмжлэг, бодлогын дэмжлэг дутаж байна.

Монголын эдийн засгийн хөгжлийн хэтийн төлөв, Зүүн хойд Ази дахь түүний оролцоо

Монгол улсын эдийн засаг уналтад ороод сэргэж чадахгүй байгаа болон Зүүн хойд Азийн орнуудын хамтын ажиллагааны тодорхой нэр бүхий томоохон төслүүд, тухайлбал байгалийн хий, цахилгаан эрчим, газрын тос дамжуулах системүүд, тээврийн сүлжээнүүдэд Монгол улс оролцох бололцоо бүдгэрэх хандлага ажиглагдаж байгаа хийгээд Зүүн хойд Азийн эдийн засгийн олон талт хамтын ажиллагаа дахь хоёр их хөршийн маань ашиг сонирхолд Монголын хөгжлийн асуудал нэг их анхаарал татахааргүй төлөвтэй байгаа нөхцлүүд Монгол улсын эдийн засгийн хөгжлийн талаар урьд өмнө хийгээд эдүгээ баримталж буй номлолыг арай өөрөөр томъёолохыг шаардаж байх шиг байна.

Сүүлийн 10 гаруй жилд Монголын эдийн засгийн хэтийн (10-15 эсхүл 15-20 жилийн) хөгжлийн талаар нарийн дүн шинжилгээ хийж, уялдуулан боловсруулсан, амьдралын гүн рүү орсон судалгаанд түшиглэсэн, шинжлэх ухааны цогц үндэслэлтэй, төр, засгийг олон удаа ээлжлэн толгойлдог улс төрийн хүчнүүд тууштай баримталдаг номлол, үзэл баримтлал гараагүй нь дээрх шаардлага үндэслэлтэй болохыг бас хэлнэ. Японы JICA, АНУ-ын USAID, UNDP зэрэг гадаадын орны болон олон улсын байгууллагын шугамаар макро эдийн засгийн тогтворжуулалт, "Sustainable development"-ийн дунд, урт хугацааны төсөл, хөтөлбөрүүд гарсан. Тэнд тавьсан зорилтууд хэрэгжээгүй л байна. Мөн түүнчлэн "Алт", "Ноолуур", "Мэдээллийн технологи" ч юм уу эсхүл "Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал", "Мянганы зам", "Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн систем" гэх мэтчилэнгийн хөтөлбөр, чиглэл, төслүүдийг төр, засгаас батлан гаргасаар байгаа.

Алт хөтөлбөр батлагдсан 1992 онд жилд 800 кг хүрэхгүй алт олборлож байснаа эдүгээ 120-оод том, жижиг ахуйн нэгжүүд жилд нийтдээ 13 тонн алт олборлож, экспортод 24% эзлэх болсон зэрэг тодорхой үр дүнд хүрсэн хэдий ч олборлолт явуулсан хөрсний дөнгөж 16%-д хагас дутуу нөхөн сэргээлт хийсэн, олон тооны гол, горхины гольдролыг өөрчлөн ширгээн, бохирдуулж байна. 1990 онд бүх мал сүргийн 20% байсан ямаагаа эдүгээ 36%-д хүргэн ноолуурын үйлдвэрлэлээ 2 гаруй дахин

нэмснээр ямаатай малчдын орлого нэмэгдэн, экспортод нааштай нөлөө үзүүлж чадсан ч байгалиас заяасан бэлчээртээ тохирсон 5 төрлийн малын сүргийн бүтэц эвдэрч, эргээд бэлчээрээ талхлах, хомсдуулах болов. Иймэрхүү жишээ дурдаад байгаагийн учир утга нь аливаа хөтөлбөр, чиглэл, төсөл шинжлэх ухааны нарийн үндэслэлтэй, иж бүрэн, нийт нийгмийн хөгжлийн асуудлуудтай бүх талын уялдаатай, үндэсний хийгээд олон улсын, бүс нутгийн түвшинд цогцоор шийдэгдсэн байх ёстойд байгаа юм. Өнөөг хүртэл төрийн тийм баримт бичиг үгүйлэгдсээр байгаа нь хөгжлийн бодлогын том дутагдал, төрийн бодлогын хямрал үүсэх үндэс юм. Энэ нь бас нийгмийн хямралын нэг үндэс гэхэд хэтрүүлэг болохгүй.

Монгол улсын Ерөнхийлөгчийн зөвлөмжийн дагуу Засгийн газраас өнгөрсөн оны эхээр үндэсний хөгжлийн урт хугацааны хөтөлбөр боловсруулах шийдвэр гаргасан. Эл хөтөлбөр нь дээр тэмдэглэсэнчлэн чанартай сайн боловсруулсан, номлол, үзэл баримтлал, зарчмыг нь улс төрийн аливаа хүчин хүлээн зөвшөөрсөн, олон улсын холбогдох байгууллага, хандивлагч, хамтрагч, хөрш, түнш орнууд дэмжсэн тийм төрийн хөтөлбөр байгаасай гэж хүсч байна.

Хөгжлийн урт хугацааны трендээс үзэхэд нэг хүнд ногдох ДНБ 1980-1990 онд жилд дунджаар 3% өсч байсан бол 1990-2001 онд 0.3%-иар буурсан. Монголын эдийн засгийг экспортын баримжаатай болгох тухай сүүлийн 40 гаруй жил ярьцгааж байгаа. Экспорт өнөөдөр үндсэндээ зэсийн баяжмал, малын түүхий эдээс бүрддэг шүүдээ. Эдгээрийг бараг бүгдийг нь хоёр хөршдөө өгдөг. Экспортын өөр төрлийн томоохон нөөц ойрын үед бий болгохгүй бол, түүхий эдээ боловсруулж сурахгүй бол Монгол улс хоёр их гүрнийхээ төдийгүй гадаад зах зээлийн түүхий эдийн хавсрага, "monoproduct" эдийн засагтай байсаар байх уу.

Зүүн хойд Азийн эдийн засгийн хамтын ажиллагаа дахь Монгол Улсын оролцоог түүхий эд нийлүүлдэг түвшингээр хэмжсээр байх уу! Үйлчилгээний эдийн засаг ч юм уу, оюуны багтаамж ихтэй үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжүүлээд, газар нутгаа гадаадынханд түрээслүүлээд, гаднаас түүхий эд зөөж боловсруулаад эсхүл өөрийн түүхий эдээ гадагш нийлүүлсээр байгаад 150 жилээс наана Монгол өнөөгийн Япон шиг баян улс болчихно гэж төсөөлөхөд хэцүү л байх.

Аль ч улс орон, үндэстэн өөр өөрийн өвөрмөц онцлогтойн адил Монгол улс мөн л тийм. Үүний сацуу дэлхийн хөгжлийн нийтлэг зарчим ч юм уу, глобалчлалын шаардлага ч юм уу, олон улсын тавцанд, улс хоорондын харилцаанд мөрддөг зах зээлийн хэм хэмжээ ч юм уу аль алиныг үндэсний хөгжилдөө харгалзах нь зайлшгүй.

Гэхдээ буурай Монголын хөгжлийг хөгжингүй орнуудын зах зээлийн эдийн засгийн макро үзүүлэлтээр зохицуулах, зээл, тусламж, дэмжлэгийн эдийн засгийн бус улс төрийн голдуу хатуу нөхцлөөр залах гэсэн хандлага олон улсын санхүү, банкны байгууллагын үйл ажиллагаанд ажиглагдаж байна. Ямар ч агуулгатай хатуу нөхцөл байлаа гэсэн эдийн засгийн түргэн өсөлтийг хангасан, ядуурлаас ангижруулсан зээл бол өөрсөн. 1990-ээд оны эхнээс Монголын нийгмийг өрнөдөд туршдаг *"shock therapy"*-аар муужруулсан шигээ эрчимт эмчилгээ хийгээд эрүүлжүүлчихсэн бол байдал өөрсөн. Монголд зохицсон өндөр хөгжлийн ямар загвар гаргачихаад түүнийгээ хэрэгжүүлэх гэж зээл олгоод байгааг эдгээр байгууллагын үйл ажиллагаанаас олж харахад хэцүү.

ОУВС, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банкны шугамаар олгож буй зээлээр өндөр үр ашигтай, өндөр технологитой, экспортын чиглэлийн ганц ч том үйлдвэр байгуулагдсангүй. Хандивлагчдын зээл, тусламжаар ч мөн л адил. Энэ юунаас болж байна вэ? Ийм үйлдвэрүүд байгуулчих эдийн засгийн анхдагч нөөц Монголд алга эсхүл дэлхийн зах зээл дээр тэдгээрээс гарах бүтээгдэхүүний эрэлтгүй болсон гэвэл бас тийм биш ээ. Зөвхөн мал аж ахуйгаас жилд богийн арьс 8 сая, бодын шир 2 сая, хонины ноос 20 мянган тонн, ямааны ноолуур 3 мянган тонн, малын яс 100 гаруй мянган тонн гардаг. Хиамын чанартай бөгөөд экологийн цэвэр түүхий эд болох богийн өлөн жилд 6-8 саяыг экспортлох нөөцтэй боловч одоогоор 200 мянга гаруйг гадагш гаргаж байгаа бөгөөд үүнээс 10 сая гаруй америк долларын экспортын орлогоо алддаг. Монголын хувьд энэ нь бага биш юм. Бэлчээрийн монгол малын булчирхай, ийлдэс, цус зэрэг эндокрин эдээс биологийн өндөр идэвхитэй бүтээгдэхүүн гаргаж болох нь аль хэдийнээ тогтоогдсон. Сүргийн нөхөн үйлдвэрлэлийн уламжлалт, зохистой бүтцийг эвдэхгүйгээр, бэлчээрийн нөөцөд нь зохицуулан, мал эмнэлэг, үржлийн ажлыг зохих түвшинд эрхэлбэл бэлчээрийн малын өндөр чанарын мах жил бүр 50 мянган тонноос доошгүйг экспортлох боломж бий. Технологий нь шинжлэх ухааны нарийн үндэстэй сонгоод арчилгааг сайн хийж чадвал Монголын дийлэнх нутгийн 1 гектараас 110 цн-ээс багагүй төмс ч юм уу, 50 цн чацаргана ч юм уу өөр бусад тарималыг авах боломжтойг практикаар ч, шинжлэх ухааны судалгаагаар ч нотолсон. Жижиг гэлтгүй ийм жишээ олон бий. 15-20 жил, түүнээс ч өмнө үйлдвэрлэлийн зэргээр, олборлоход бэлтгэсэн эрдсийн гаралтай бүтээгдэхүүний экспортын зарим томоохон нөөц байгаа: *Баруун бүсэд* Асгатын мөнгө, *Хангайн бүсэд* Бүрэнхааны фосфор, *Төвийн бүсэд* Цагаан суваргын зэс, Төмөртэйн төмөр, Таван

толгойн коксжих нүүрс, *Зүүн бүсэд* Мардайн уран, Цав, Улааны холимог металл, Төмөртэйн овооны цайр зэргийн ордууд юм.

Олборлон баяжуулахад бэлтгэсэн нүүрсний 6 тэрбум тонн нөөцөөс жилд 10 сая гаруйг эл түүхий эдийн томоохон эрэлттэй гэж үздэг ОХУ-ын Сибирь, БНХАУ-ын Өвөр Монголын хэрэгцээнд зориулан нийлүүлэхэд одоогийн экспорттой дүйх орлого бий болно. Эзэмшээгүй дээрх ордуудад гадаадын хөрөнгө оруулалт, зээл, олон улсын санхүүгийн эх үүсвэрийг татаж чадвал, гадаад зах зээлээ олж чадвал Монголын экспортыг ойрын 10 жилд 3 дахин өсгөх боломж олдож болох ба энэ нь үндсэндээ 1989 оны экспортын хэмжээнээс 50% л дээгүүр болно. Үүн дээр мал аж ахуйн түүхий эдээр эцсийн бүтээгдэхүүн хийж экспортолбол дээрх өсөлтөд 1/3-ээс доошгүй нэмэр болно. Иймэрхүү маягийн өсөлт хангалттай биш юм. Монголын эдийн засагт үүнээс өндөр өсөлт бий болгох, эрсдэлийг нь багасгах боломжийг хайх шаардлагатай.

Хөгжлийн өндөр өсөлт бий болгохын тулд зарчмын дараах үндсэн асуудалд анхаарах нь зүйтэй болов уу гэж үздэг. *Эхний асуудал бол Монголын эдийн засгийн хөгжлийн тулгуур номлол, загвартай холбоотой.* Эдийн засгийнхаа хөгжлийн талаар Монголын эрдэмтэд, судлаачдаас хийсэн, хийж байгаа судалгаа, шинжилгээний ихээхэн зэхэц бий бөгөөд хөгжлийн эдийн засгийн ерөнхий онолын хувьд онцгойлон гаргаад тавьчихсан шинэлэг загвар одоохондоо байхгүй байна. Энэ нь Монголын эдийн засагт хөгжлийн номлол, загвар шаардлагагүй гэсэн хэрэг биш нь мэдээж. Онолын талаасаа ч, практик хэрэгцээ талаасаа ч *аж үйлдвэржүүлэлт* Монголд хэрэгтэй. Дэлхийн олон улсууд өндөр хөгжилд хүрэхдээ энэ арга замыг хэрэглэж, олон улсын хөдөлмөрийн хуваарь эл замаар өргөжиж гүнзгийрсээр ирсэн. Энэ бол цоо шинэ арга зам ч биш, гэхдээ үеэ өнгөрөөсөн хуучин нь ч биш. Технологийн хувьсгалаар шинэчлэгдэж буй, шинэчлэгдэх энэ арга зам өнөөдөр ч, ирээдүйд ч хөгжлийн өндөрлөгт аваачих нь нотолгоо шаардаад байх зүйл биш байх аа. Хөгжингүй орнууд, тэдгээрийн үндэстэн дамнасан корпорацууд дэлхийн аж ахуйн бүтцийн хамгийн дээд буюу ашиг их өгдөг давхрууд болох боловсруулах аж үйлдвэр, үйлчилгээний секторуудыг эзэмддэг. Тэдний зиндаанд хүрдэггүй юм гэхэд өндөр технологиор, өндөр бүтээмжтэй, өндөр үр ашигтай үйлдвэрлэл эрхэлж, олон улсын стандартад, гадаад зах зээлийн эрэлтэд нийцсэн өндөр чанарын бүтээгдэхүүн хийж байж л сая дэлхийн болон бүс нутгийн зах зээлийн өрсөлдөөнд уначихгүй, эдийн засгаа өөд татаж, хурдан өсөлттэйгээр авч явах нь ойлгомжтой.

Манай улс төрчид, судлаачид бүгд л бичиж, ярьж байдаг сэдэв. Харамсалтай нь яриа, лоозунгаас, улс төрийн амлалтаас хэтрэхгүй байгаа юм. Монголчууд бид аж үйлдвэржүүлэлтийг орчин үеийн зорилго, агуулга, цар хэмжээ, арга хэлбэр зэрэг аль ч талаар нь хэрэгжүүлж сураагүй байгаа. 1960-1980-аад оны үеийн улс төр, үзэл суртлын зарчимд хөтлөгдсөн, дэлхийн зах зээлийн нөхцлөө, дэлхийн хөдөлмөрийн хуваариа харгалзаагүй аж үйлдвэржүүлэлт, 1990-ээд оноос эдүгээ болтол үргэлжилж байгаа үндэсний том үйлдвэрлэлээ устгасан, өндөр технологи хэрэглэх санхүү, эдийн засгийн чадваргүй, олон улсын зах зээлд өрсөлдөж чадахуйц өндөр чанарын бүтээгдэхүүн хийж чадахгүй жижиг үйлдвэрлэлийг хэт шүтсэн өрөөсгөл бодлогыг давтахгүй байхсан.

Ойрын ирээдүйн Монголын аж үйлдвэржүүлэлтийг бодит салбарын чиглэлээр хураангуйлан томъёолъё гэвэл:

- энэ бол юуны өмнө хөдөө аж ахуйн гаралтай, нөхөн сэргээгддэг түүхий эдээ өндөр бөгөөд хаягдалгүй технологиор боловсруулах;
- энэ бол био нөөцөө бүрэн бөгөөд зохистой ашиглах аж үйлдвэрийн аргыг нэвтрүүлэх, эрсдэл өндөр хөдөө аж ахуйгаа баталгаатай болгох;
- энэ бол олборлон боловсруулахад бэлэн болсон ашигт малтмалын нөөцийг аж ахуйн эргэлтэд түргэн оруулж эцсийн бүтээгдэхүүнээр биш юмаа гэхэд хагас боловсруулан гаргах уул уурхайн аж үйлдвэрийн томоохон бүтэцтэй болох;
- энэ бол үндэстэн дамнасан аж үйлдвэрийн дэлхийн томоохон корпорацууд тэргүүний технологиороо Монголын түүхий эдийн нөөцийг Монголын нутагт боловсруулах;
- энэ бол геологийн эрэл, зураглалын ажлыг өргөн цар хүрээтэй, түргэн, өндөр магадлалтай явуулах орчин цагийн техник, аргыг хэрэглэх;
- энэ бол уламжлалт хийгээд ус, нар, салхины үүсгэвэрийг ашиглан төв, суурин газар төдийгүй ойр, холын айл өрхийг цахилгаан эрчмээр хангах;
- энэ бол мэдээлэл, холбооны орчин үеийн технологи бүхий бүтцийг орон даяар бий болгох;
- энэ бол түргэн өсөх нийгэм, эдийн засгийн ачаалал, том үйлдвэрлэлийг үйлчилж чадахуйц тээврийн үндэсний сүлжээ, түүнтэй холбоотой олон

улсын болон бүс нутгийн тээврийн коридоруудыг бий болгох гэх мэтчилэнгээр үргэлжлүүлж болох бөгөөд эцсийн дүндээ энэ бүхэн нь Монголын эдийн засаг орчин үеийн өндөр үр ашигтай аж үйлдвэржсэн бүтэцтэй болно гэсэн хэрэг юм.

Ийм бүтцээр л Зүүн хойд Азийн эдийн засаг дахь Монголын оролцоо тодорхойлогдох болов уу. *Хоёрдахь асуудал бол бодит эдийн засаг дахь суурь бодлого юм.* Дэлхийн түвшингийн технологид тулгуурласан, олон улсын зах зээлийн эрэлтэд нийцсэн *том үйлдвэрлэлийг* хөгжүүлэх явдал аж үйлдвэржүүлэлтийн суурь бодлого байвал зүйтэйсэн. Монгол Улс эдүгээ 186 мянган малчин өрх, 13 мянган компани, 10 мянган хоршоо, нөхөрлөл зэрэг аж ахуйн субъектүүдтэй. бөгөөд эдгээр нь хэт жижгэрснээс гадна төрөлжилт, хоршилтоор маш сул, эрсдэл өндөр, жинхэнэ амиа хичээсэн натурал хэвшлийн ноёрхлын мөн чанарыг харуулдаг. Төрийн захиргаадалтаар эсхүл зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн тохироо буюу “үл үзэгдэх гараар” эдгээрийг нэгтгэж томсгоод том үйлдвэрлэл, том аж ахуй болгочихгүй нь ойлгомжтой. Нөгөөтэйгүүр жижиг үйлдвэрлэлийн үүрэг ролийг дутуу үнэлж бүгдийг томсгох эсхүл бүгд том байна гэвэл бас л туйлшрал болно. Том үйлдвэрлэлийн бодлого нь юуны өмнө түүхий эдийн томоохон нөөцүүдийг өргөн цар хүрээтэйгээр, дээд үр ашигтайгаар боловсруулдаг өндөр технологи нэвтрүүлэх, шинэтгэл хийх санхүүгийн маневртай, төрөлжилт, хоршилт, бөөгнөрлийг дотоод, гадаад хүрээгээр зохистой хослуулж чадсан, чанар сайн бүтээгдэхүүнээр олон улсын зах зээлд өрсөлдөх чадвартай, дэлхийн түвшний менежменттэй, нарийн мэргэжлийн ажиллах хүчээр хангагдсан, нийгэм, соёлын асуудлыг бие дааж шийдвэрлэдэг, улсын эдийн засгийн ноён нуруу нь болох тийм эдийн засгийн бүтцийг бий болгоход оршивол зохистой. Ийм бодлогыг бодит ажил болгохын тулд Монголын эдийн засгийн бодлогод зарчмын зарим өөрчлөлт хиймээр байгаа юм. Тухайлбал:

1. Монгол орон байгалийн их баялагтай мэтээр манайд ер нь янз бүрийн түвшинд ярьцгааж, сурталчилдаг. Энэ талаарх миний ойлголт бол арай өөр. Олборлож боловсруулахад бэлэн нөөцийн байдал ямар байгааг өмнө товч өгүүлсэн, ийм нөөцөөр өндөр хөгжилд хүрч чадахгүйг тэмдэглэсэн. Геологийн сангийн мэдээгээр 80 орчим төрлийн эрдсийн 6 мянга гаруй, барилгын материалын 170 орчим орд, илрэл эдүгээ байгаа бөгөөд 200 орчмыг ашиглаж байна. Эдгээр орд, илрэлийн 90% гаруй нь баримжаалсан, таамагласан нөөцийн үнэлгээтэй, үйлдвэрлэлийн зэрэглэлийн нөөц тогтоох нарийвчилсан хайгуул, өрөмдлөг хийгдээгүй. 1:50000

масштабын эрэл, зураглалын ажил нийт нутгийн ердөө 1/6-ийг хамраад байгаа шүүдээ. Эдгээр нь нэг талаас үзэхэд Монголын нутаг ашигт малтмалаар нэлээд арвин байж болох магадлалтай ч, нөгөө талаасаа их баян гэж хэтрүүлж бас болохгүй болов уу. Төв Азийн тектоник зүй тогтлоор Тян Шаны гэгдэх бүсийн Өмнөговийн ай савд зэс, алтны агуулга сайтай, багагүй нөөцтэй бүлэг ордууд нээж байгаагаа олон улсын Ivanhoe Mines¹⁰ компани мэдээлэх болов. Эдгээр дэлхийн ангиллын хэмээн үзэж буй 5 том бүлэг ордын зөвхөн Оюу толгойн ордоос жилд 300 мянган тонн зэс, 10 тонн алт үйлдвэрлэх урьдчилсан концептуал төлөвлөгөө гаргаснаа зарлаж байна. Оюу толгойгоос хойш 120 км-т орших Хармагтайн ордын металлын агуулга нэг тоннод алт 2.99 гр, зэс 5.94%-тойг илрүүлжээ. Энэ мэтээр Монгол Алтайн ай сав дахь газрын ховор элементүүд, Хангай, Хэнтийн блок дахь зэс, алт, нүүрс, Зүүн бүс нутаг дахь хайлуур жонш, холимог металл, Өмнөговийн ай сав дахь зэс, алт, газрын тос, нүүрсний орд, илэрцийн бүсүүдэд эрдсийн том том нөөцтэй ордыг нээх шинжлэх ухааны таамаг дэвшүүлж болох ба тийм нөөцийг үйлдвэрлэлд бэлтгэсний дараа л Монгол орон эрдсийн баялагаар арвин эсэхэд тодорхой хариулт өгч чадна. Энэ нь геологийн эрэл, зураглалын ажлын цар хүрээг маш ихээр өргөтгөх, үүнд юуны өмнө санхүүгийн үлэмж хэмжээний нөөц чиглүүлэхийг шаардана. Энэ ажлын үр дүнгээр Монголын ойрын хийгээд алс хэтийн ирээдүйн хөгжлийн төлөвийг хэмжих байх. Энэ ажлын цар хэмжээ, үр дүнгээр Зүүн Хойт Ази дахь Монголын эдийн засгийн оролцоо үндсэндээ хэмжигдэнэ байх. Энэ ажилд бүс нутгийн орнууд хэр зэрэг оролцсоноор Монгол дахь тэдгээрийн хамтын ажиллагааны түвшин хэмжигдэнэ байх. Монголыг өндөр хөгжилтэй болгоход Зүүн хойд Азийн орнууд хэрхэн хамтран ажиллаж байна вэ гэдэг нь харагдана. Түүхий эдийн нөөц хичнээн арвин байсан ч тэдгээрийн гадаад зах зээлийн хэрэгцээ, үнийн хандлага, олборлон боловсруулах технологийн арга, санхүүгийн хангамж, менежмент, гадаад улс төрийн нөхцлөө нэгэн зэрэг тооцож байхгүй бол яг өнөөдрийн байдалд буюу бэлэн түүхий эдийн нөөцөө боловсруулж, зах зээлд нийлүүлж чадахгүй суух болно. Манай бүс нутгийн улсуудаас нэгэн ч өнөөдөр геологийн дорвитой томоохон эрэл, зураглалын ажлыг Монголд хийхгүй байна.

Сүүлийн 10 гаруй жилд ОХУ-аас 100 хувийн хөрөнгө оруулалттай нэг компани алт олборлож байгаагаас өөр эрдэс олборлох, баяжуулах, боловсруулах нэг ч үйлдвэрийг дангаараа эсхүл хамтраад шинээр байгуулсангүй. БНХАУ-ын хөнгөлттэй зээлээр цайрын нэг ордыг л ашиглахаар ажиллаж байна. Дэлхий даяар үйл

¹⁰ www.ivanhoemines.com

ажиллагаагаа явуулдаг Япон, Өмнөд Солонгосын үндэстэн дамнасан корпорацуудаас ноолуур боловсруулах, алт олборлоход зээл өгснийг эс тооцвол Монголд олборлох томоохон үйлдвэр нэгийг ч байгуулсангүй.

2. Үүний өмнө би эрдсийн түүхий эдээ боловсруулж улмаар экспортын баримжаатай, орчин үеийн аж үйлдвэржсэн бүтэцтэй эдийн засагтай болох тухай хөндсөн. Гэтэл эрдсээр тийм ч баян биш байвал, бас нөхөн сэргээгддэггүй нөөц гэдгийг тооцвол яах вэ гэсэн хэнд ч ойлгомжтой асуулт гарна. Нэг жишээ авъя. Сингапур Улс 1965 оноос өмнөхөн Малайзийн бүрэлдэхүүнд байхдаа нэг хүнд ногдох үндэсний орлогоор одоогийн манай хэмжээнд байсан. Одоо тэд бид нараас 63 дахин илүү орлоготой болж чадсан. Хүн амын тоогоор ойролцоо, эх газрын үргэжлэл болох 1 мянган км² нэгэн жижиг арал дээр орших энэ хот-улсад бидэнд одоо байгаа шиг олон сая мал, газрын их нөөц, эрдсийн баялаг байгаагүй, одоо ч байхгүй. Өнөөдөр Сингапурын нэг хүнд ногдох экспорт үндэсний орлогоосоо 40 дахин дээгүүр. Эдийн засгийн хэллэгээр бол энэ улс нэмүү өртөг үйлдвэрлэж баян болсон. Өмнөд Солонгосын нэг хүнд ногдох үндэсний орлогын 1972 оны хэмжээ одоогийн манай түвшинтэй ижил байсан бол 30 жилийн дотор 23 дахин өсгөсөн. Хүрсэн гол арга зам нь Сингапурынхтай төстэй. Монгол Улсын хөгжлийн альтернатив сонголтод ийм арга зам тооцогдох ёстой болов уу.

3. Буурай эдийн засагтай аль ч улсад санхүүгийн их хэмжээний хомсдол байдаг ч эл хомсдол манайд дотоод, гадаад хүчин зүйлсийн нөлөөгөөр улам хурцдаг байна. Олон улсын санхүү, банкны институцийн багагүй оролцоотойгоор үндсэндээ үйлчилгээний секторт мөнгө хүүлэх тогтолцоог л өөгшүүлээд буй төрийн мөнгө, зээлийн бодлогыг өөрчилж үйлдвэрлэл, экспорт өсгөхөд чиглүүлбэл хэнд ч ойлгомжтой. Гадаад зээл, тусламж, дэмжлэгийг өөрийгөө нөхөх чадвартай үйлдвэрлэлд зориулахаар гол чиглэлийг нь өөрчлөх шаардлагатай. Үндэсний хувийн хэвшлийнхэн санхүүгийн нөөцөөр хомс, барьцаалах хөрөнгөгүй байгаа нөхцөлд гадаад зээлийг Засгийн газар өөрөө ашиглах эсхүл хувийн хэвшилд зуучлах мэтийн төрийн арга хэрэгслийг түлхүү хэрэглэхгүй бол эдийн засгаа өөд татчих том том үйлдвэрлэлийг бий болгох нь их эргэлзээтэй. Бүгдийг хувьчилчихаад татвараа хараад суудаг төр байж боломгүй санагдана. Өнөөгийн хандлагаар бол татвараасаа өрөө төлөөд ч дийлэхээ болино. Өрийн асуудал өнөөдөр хоёр үзүүртэй тэвнэ мэт байдаг гэвэл хэтрүүлэг болохгүй байх. Их өр бодлогоор дарамтлах хэрэгсэл болж байна. Үүнийг ойрын үед эс шийдэвээс Монголын хэтийн төлөвт нааштай үр дагавар

авчрахгүй. Их өрийг шийдэхгүй байвал гадаадаас үр өгөөжтэй зээл, тусламж авахад саад тотгор үзүүлэхгүй гэх газаргүй.

4. Цаг уурын тааламжгүй нөхцөлтэй гэдгээр өргөн уудам газар нутгийнхаа хөрсний үр шимийг хүртэж, газартай харьцаж сурахгүй байвал, газрын гадаргуугийн нөөцөө зокистой ашиглахгүй байвал хөгжлийн том нөөц орхигдуулсан хэрэг болно. Энд усжуулалт шийдвэрлэх үүрэгтэй болов уу, Монгол оронд нүүрэлчихээд байгаа цөлжилтийг сааруулах, экологийн тэнцвэрийг сайжруулах глобаль үр нөлөөтэй төдийгүй хөдөө аж ахуйг нь байгаль, цаг уурын эрхшээлээс бага ч болов гаргах, эл секторын эрсдэлийг нь багасгах, хөгжлийг нь тогтвортой болгох, нүүдэллэн эрхлэх мал аж ахуйг хагас суурин, суурин хэв шинж рүү оруулах, эрчимжсэн аргад шилжих, баталгаатай тариалан эрхлэх, улмаар экологийн цэвэр хүнсээр өөрийгөө хангах, бас ч экспортлох цорын ганц зам байхыг үгүйсгэхэд хэцүү. Агротехникийн арга ухаан их дутаж байгаа ч усгүйгээс, гангаас болж бэлчээр ногоогүй, мал усгүй, тэжээлгүй, тариалан ургацгүй шахуу хоцорч байгааг юуны өмнө усжуулалттай л холбож үзвэл зүйтэйсэн.

5. Хүний нөөцийн сайн менежменттэй, улс орноо удирдан зохицуулах өндөр ур чадвартай болох нь өндөр хөгжлийн нэг гол түлхүүр юм. Энэ талаар сүүлийн жилүүдэд гаргасан том алдаа, туйлшралаа дурсаад өнгөрөх биш сургамж авах зүйл олон бий. Жишээлбэл, Монголын хөвгүүд, охид зуу зуугаараа гадаад оронд бакалавр, магистрын зэргийг хамгаалж байгаа боловч тэдний дотор байгаль, техник, хөдөө аж ахуй, тодорхой үйлдвэрлэлийн технологийн чиглэлийнх тун ховор байгаа нь технологийн дэвшил хийх ёстой эдийн засгийн маань хүний нөөцийн менежмент хэр зэрэг байгааг харуулна.